



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2015 оны 11 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 239

Улаанбаатар  
хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

1. Төрийн өмчит холдинг компанийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн эцэслэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг 1 дүгээр хавсралт ёсоор, Ажлын хэсгийг мэдээллээр хангаж, техникийн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус байгуулсугай.

2. Төрийн өмчит холдинг компанийн хуулийн төслийг 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор эцэслэн боловсруулж Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулахыг Ажлын хэсэг (М.Энхсайхан)-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Ерөнхий сайдын 2015 оны 239 дүгээр  
захирамжийн 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ ХОЛДИНГ КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙГ ЭЦЭСЛЭН БОЛОВСРУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч	-Монгол Улсын сайд М.Энхсайхан
Гишүүд:	-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт; -Хууль зүйн сайд Д.Дорлигжав; -Сангийн сайд Б.Болор; -Уул уурхайн сайд Р.Жигжид; -Эрчим хүчний сайд Д.Зоригт; -Зам, тээврийн сайд М.Зоригт.
Нарийн бичгийн дарга	Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Дэлгэрмаа.



Ерөнхий сайдын 2015 оны 239 дүгээр  
захирамжийн 2 дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАЖ, ТЕХНИКИЙН  
ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ҮҮРЭГ БҮХИЙ ДЭД АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ахлагч -Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Дэлгэрмаа
- Гишүүд:
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Мөнх-Эрдэнэ;
  - Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр;
  - “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хуулийн ахлах зөвлөх Б.Сүндэръяа;
  - Эдийн засгийн үндэсний хорооны судлаач Д.Баасанхүү;
  - Эдийн засгийн үндэсний хорооны судлаач Н.Энхбаяр;
  - Ерөнхий сайдын ажлын албаны референт С.Батцэцэг;
  - Ерөнхий сайдын ажлын албаны референт Э.Хосбаяр.